

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН
ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

(НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ)

2026 ОН

| | |
|---|----|
| УДИРТГАЛ | 3 |
| НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ | 4 |
| 1.1. Зорилгод хүрэх байдал: | 4 |
| 1.2. Ойлгомжтой байдал: | 4 |
| 1.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: | 4 |
| 1.4. Харилцан уялдаа: | 4 |
| ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ | 5 |
| 2.1. Зорилгод хүрэх байдал: | 5 |
| 2.2. Ойлгомжтой байдал | 8 |
| 2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал | 8 |
| 2.4. Харилцан уялдаа | 8 |
| ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ | 8 |
| 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал: | 9 |
| 3.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал | 12 |
| 3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал | 14 |
| 3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал | 16 |
| ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ | 18 |
| 4.1. Баримтжуулалт | 18 |
| 4.2. Үнэлэлт, дүгнэлт | 18 |

УДИРТГАЛ

Энэхүү ажлын зорилго нь “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу тодорхой шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэх, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийх хуулийн төсөл нь “Анхдагч” хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан болно.

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу дараах үе шаттайгаар хийж, дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, зорилт, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан доорх 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1.1. Зорилгод хүрэх байдал:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн үндсэн зорилго нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлагыг бүрэн илэрхийлсэн эсэхийг дүгнэн, хуулийн төслийн зорилго тус зохицуулалтыг бий болгоход чиглэж буйг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлсэн.

1.2. Ойлгомжтой байдал:

Хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах байдлаар энэхүү шалгуурыг сонгосон.

1.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн зохицуулалтад шууд хамаарах этгээд хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгахын тулд сонгосон болно.

1.4. Харилцан уялдаа:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөг үнэлгэхээр сонгосон.

Хүснэгт 1

| № | Шалгуур үзүүлэлт | Агуулга | Хамрах хүрээ |
|---|-----------------------|--|--------------------------|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Төслийн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцно | 1.1, 5.1, 6-р зүйл |
| 2 | Ойлгомжтой байдал | Зохицуулалт нь хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд | 4, 6-7, 9-13 дугаар зүйл |

| | | | |
|---|----------------------------|--|-------------------|
| | | ойлгомжтой, логик дарааллаар боловсруулагдсан эсэхийг шалгана | |
| 3 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Төслийн зохицуулалтыг нийгмийн харилцаанд оролцох бүх субъект хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг шалгана | Судалгааны үр дүн |
| 4 | Харилцан уялдаа | Төсөл нь МУ-ын Үндсэн хууль болон бусад хуулийн зүйл заалттай нийцэж байгаа эсэхийг шалгана | Бүх зүйл, заалт |

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий холбогдох зүйл, заалтыг сонгосон.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг байгаа эсэх, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр нэгж үүсгэх шаардлагатай зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцсон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг үнэлж үзье.

2.1.Зорилгод хүрэх байдал:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн.

Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээний дагуу хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар хүлээсэн үүргийн дагуу Хүүхдийн эрхийн тухай хуулийг 2016 онд, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 онд тус тус баталсан бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын харилцааг хуульчилсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт “25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталсан. Тус журмаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15, 4.1.16-д

заасан хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулах бол Зөвлөл хүүхдэд хортой агуулгатай эсэх дүгнэлтийг гаргахаар зохицуулсан байна.

Мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-т хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллахаар зааж, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоолоор уг зөвлөлийг байгуулсан.

Монгол Улсын УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Харилцаа холбоо, технологийн газрын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/68 дугаартай тушаалаар “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл” баталсан бөгөөд эдгээр баримт бичгүүдэд Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэхээр зорилго, зорилтууд тусгагдсан боловч одоогоор тогтолцоо хангалттай бүрдээгүй байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц буюу хүүхдийн эрхийн тухай цогц хэм хэмжээ бүхий баримт бичгийг 1989 оны 11-р сарын 20-ны өдөр баталснаас хойш 193 орон нэгдэн орсон ба уг конвенцод Монгол Улс 1990 онд нэгдэн орсон байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2-р зүйлд хүүхэд гэдэг 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ гэж заасан. Тухайн конвенцод хүүхдийн суурь дөрвөн эрхийг заасан нь амьд явах эрх, хөгжих эрх, хамгаалуулах эрх болон оролцох эрх юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 24 дүгээр зүйлийн 1-д “Аливаа хүүхэд яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй.” гэж, Хүүхдийн эрхийн тухай конвенцын удиртгалд “хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай.” талаар дурдаад, тус конвенцын 19 дүгээр зүйлийн 1-д “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг эрх бүхий асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сэргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.” гэж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Цахим орчинд хамаарах хүүхдийн эрхийн тухай 25 дугаар нэмэлт тайлбарыг 2021 онд баталсан бөгөөд уг нэмэлт тайлбарын 23-т “Оролцогч улсууд нь цахим орчныг

Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Нэмэлт тайлбарт заасан эрхтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг шинэчилнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын нийт хүн ам 3.5 сая байгаагаас ухаалаг төхөөрөмж хэрэглэгчдийн тоо 4.4 саяд хүрсэн байгаа бөгөөд интернэт (4G) хэрэглэгчдийн тоо 4.2 сая, Фэйсбүүк нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо 2025 оны байдлаар 2.9 сая буюу 83 хувьтай байна. Монгол Улсад 2025 оны байдлаар нийт хүн амын 36,2 хувь буюу 1.3 сая 0-17 насны хүүхэд байна.

Монгол Улсын нийт хүүхдийн цахим хэрэглээ өсөж, нийгмийн сүлжээний эрсдэл нь үндэсний хэмжээнд хүүхэд хамгааллын асуудал болсон нь холбогдох судалгаанаас харагдаж байна. Боловсролын яамны 2022 онд явуулсан судалгаагаар хүүхдийн 46% нь өдөрт 2 - 4 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг, 79% нь нийгмийн сүлжээ ашигладаг бол эцэг, эхийн судалгаагаар хүүхдийн 67.1% нь өдөрт 1-5 цаг, 17.2% нь 5 цагаас дээш хугацааг цахим орчинд өнгөрүүлдэг байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн 2025 онд хийсэн судалгаагаар 9–12 насны хүүхдийн 30% нь, харин 13–17 насны өсвөр үеийнхний 51.3% нь доромжлол, зарим тохиолдолд цахим дээрэлхэлтийн улмаас бэлгийн дарамтад өртөж хохирогч болж байгаа нь тогтоогдсон. Түүнчлэн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 90% нь нийгмийн сүлжээний үйлчилгээ (фэйсбүүк гэх мэт) ашиглах насны шаардлага хангаагүй хэдий ч тогтмол ашигладаг гэж хариулжээ.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны хүрээнд хүүхдүүд хортой контент, цахим дээрэлхэлт, танихгүй хүнээс ирэх зурвас, хувийн мэдээлэл алдагдах зэрэг эрсдэлд өртөж байна. Тухайлбал, хүүхдийн 22% нь заналхийлсэн, доромжилсон зурвас авч байсан, 56% нь буруу зүйлд уруу татсан агуулгатай мэдээлэлтэй тааралдаж байсан байна. Багш нарын 52.2% нь сурагчдад зан төлөвийн өөрчлөлт, 45.2% нь аливаа сэтгэл зүйн асуудал, 42.1% нь цахим хэрэглээний донтолт ажиглагддаг гэсэн байна.

Иймд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, гомдол мэдээлэл шийдвэрлэх, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго, хэрэгцээ шаардлагад үндэслэн Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Нийгмийн сүлжээ, тэдгээрээр түгээгдэж буй агуулгын хүүхдэд учруулж болзошгүй эрсдэлийн түвшинд үндэслэн хандалтын хязгаарлах болон хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог

- сайжруулах;
- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг зөрчсөн эсхүл хортой агуулгыг хориглох болон устгах;

2.2. Ойлгомжтой байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалган, үр нөлөөг тооцно.

2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, хүүхэд, боловсролын байгууллагаас санал авах, асуулга явуулах замаар хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг үнэлсэн.

2.4. Харилцан уялдаа

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тусгасан стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 2.

| № | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|----|-----------------------|---|---|
| 1. | Зорилгод хүрэх байдал | Тандан судалгааны үеэр тодорхойлсон асуудлыг хуулиар зохицуулсан харилцааг тусгасан байдал. | Зорилгод дүн шинжилгээ хийх |
| 2. | Ойлгомжтой байдал | Хуулийн төслийг бүхэлд нь тооцно. | Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах |

| | | | |
|----|----------------------------|---|--|
| 3. | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судалгааны асуулгаар тооцно | Оролцогч талуудаас судалгааны асуулгаар шалгах |
| 4. | Харилцан уялдаа | Хуулийн төслийг бүхэлд нь тооцно. | Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах |

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Энэ хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгаагаар тодорхойлсон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зохицуулалтуудын үр нөлөөг үнэллээ.

Хүснэгт 3.

| № | Тандан судалгаагаар тодорхойлсон асуудал | Хуулийн төсөлд тусгагдсан байдал |
|----|--|---|
| 1. | Нийгмийн сүлжээнд хүүхдийн хэрэглээг зохицуулах, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоо хангалтгүй байна | Хуулийн төслийн 6 дугаар зүйлд зааснаар нийгмийн сүлжээг хүүхдэд насны хязгаарлалттайгаар ашиглуулах зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 15-р зүйлд сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хязгаарлалт хийж, хяналт тавих, бүх түвшний боловсролын байгууллагад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг үүргийг тусгасан байна. |
| 2. | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээ, эрсдэлийн талаарх агуулга хангалтгүй байгаа тул сургалтын гарын авлага, модуль, хэрэглэгдэхүүн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн байна. | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах агуулгыг үе шаттайгаар тусгаж, нийгмийн сүлжээний эрсдэлийн талаарх мэдлэг, ур чадвар олгох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгасан. Мөн хуулийн төслийн 10.2.3. суралцагчид |

| | | |
|----|--|--|
| | | нийгмийн сүлжээнд хувийн мэдээлэл хамгаалах, нууцлал, аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаарх мэдлэг, дадал олгохыг боловсролын байгууллагад үүрэг болгосон байна. |
| 3. | Интернэтийн үйлчилгээ эрхлэгчид насанд хүрээгүй хэрэглэгчдэд зориулсан сөрөг мэдээлэл шүүх программ, хамгаалалтын хэрэгслийн талаар мэдээлэл өгөх үүргийг хуульчлан зохицуулах шаардлагатай байна. | Хуулийн төслийн 12 дугаар зүйлд харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчид үүрэн холбооны дугаарыг 16-аас доош насны хүүхдүүдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох, улмаар нийгмийн сүлжээнд түгээсэн хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар үүргүүдийг тусгасан байна. Ингэснээр интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нь зохисгүй агуулгыг сүлжээний түвшинд хязгаарлах техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлж, хүүхдийг цахим орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч болох эрх зүйн үндэс бүрдэхээр байна. |
| 4. | хүүхдийн цахим орчны хэрэглээ, эрсдэлийн талаарх судалгаа, шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажил тогтмол, системтэй хэрэгжихгүй байна. | Хуулийн төсөлд 7.3-т нийгмийн сүлжээний үйлчилгээнд хүүхдэд учруулах эрсдэлийг үнэлэх, түүний үр дүнд үндэслэн нийгмийн сүлжээг зохицуулалттай болон бусад гэж ангилахаар зохицуулсан байна. Түүнчлэн хуулийн төсөлд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт 16.1.5."нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бүхий зохисгүй агуулгад дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг хүүхэд, гэр бүлийн, цахим хөгжил, харилцаа холбооны, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах" гэж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт 17.1.5. "нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, дүн шинжилгээ хийх, нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах санал боловсруулж, дээд шатны |

| | | |
|----|--|--|
| | | байгууллагад уламжлах” гэж тус тус зааж, холбогдох байгууллагуудыг үүрэгжүүлсэн байна. |
| 5. | хүүхдийн интернэтийн хэрэглээний хугацаа өсөж байгаа боловч эцэг, эхийн хяналт хангалтгүй байна. | <p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд эцэг эх, асран хамгаалагч, харгалзах дэмжигчийг хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавихыг үүрэг болгосон байна. Түүнчлэн хуулийн төслийн 9.2-т зааснаар эцэг эхийн хяналтын хэрэгсэл ашиглаж хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах, гэр бүлийн орчинд хүүхдийн ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар тохиргоог идэвхжүүлэх, зохисгүй агуулгад өртөхөөс хамгаалах, хүүхэд нийгмийн сүлжээнээс хэт хамааралтай байхаас урьдчилан сэргийлэх, хүүхдийнхээ ашиглаж буй харилцаа холбооны сүлжээний дугаарыг хүүхдийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт үнэн зөвөөр бүртгүүлэн, хэрэглээнд хяналт тавихыг үүрэг болгосон.</p> <p>Түүнчлэн хуулийн төсөлд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийн ашиглаж буй нийгмийн сүлжээний үйлчилгээний талаар мэдлэгтэй байх, цахим ур чадвараа дээшлүүлэх сургалт, зөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагаас авдаг байхыг үүрэг болгосон байна.</p> |
| 6. | Хүүхдийг зохисгүй, сөрөг нөлөө бүхий контентоос хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байна. | <p>Хуулийн төсөлд нийгмийн сүлжээг 13 насанд хүрээгүй хүүхдэд ашиглуулахгүй байх, 13–16 насны хүүхдэд зохицуулалттай ашиглуулахаар тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээ, түүний хугацаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хяналт тавих боломжийг бүрдүүлэх; • хүүхдийн хувийн мэдээлэл, байршил болон бүртгэлийн нууцлалыг хамгаалах анхдагч тохиргоо хэрэгжүүлэх; • танихгүй хэрэглэгчтэй харилцаа тогтоох, шууд дамжуулалт хийх боломжийг хязгаарлах; |

| | | |
|--|--|---|
| | | <ul style="list-style-type: none"> • зохисгүй агуулгын харагдац, түгээлт, санал болгох алгоритмыг хязгаарлах, тухайн агуулгыг хаах, мэдээлэх, гомдол гаргах технологийн боломжийг бүрдүүлэх; • зохисгүй агуулгыг мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломжийг бүрдүүлэх; • хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн бусад технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтууд тусгагдсан байна. |
|--|--|---|

3.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн бүтэц, эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

Мөн бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Хүснэгт 4.

| № | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн агуулгад тавих нийтлэг шаардлага | Нийцтэй байдал |
|----|--|---|
| 1. | Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт | Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал |
| 2. | 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан. |
| 3. | 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; | Уг шаардлагыг хангасан байна. |

| | | |
|-----|---|---|
| 4. | 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; | Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй. |
| 5. | 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх; | Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. |
| 6. | 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 7. | 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх; | Энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. |
| 8. | 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх; | Хуулийн төслийн дурдсан бусад хуулиудыг зохих байдлаар эшилсэн буюу хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх тул энэ шаардлагыг хангасан байна. |
| 9. | 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 10. | 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; | Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд хариуцлагын талаар зохих байдлаар тусгасан, уг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тодорхой тусгасан тул уг шаардлагыг хангасан байна. |
| 11. | 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; | Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх тул уг шаардлагыг хангасан байна. |

| | | |
|---|--|---|
| 12. | 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. | Уг шаардлагыг хангасан байна. |
| Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага | | |
| 13. | 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх; | Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. |
| 14. | 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх; | Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. |
| 15. | 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; | Уг шаардлагыг хангасан байна. |
| 16. | 30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх; | Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. |
| 17. | 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх. | Уг шаардлагыг хангасан байна. |

3.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү хуулийн төслийн хүрээнд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, гомдол, мэдээлэл шийдвэрлэх, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд хүүхдийг нийгмийн сүлжээн дэх зохисгүй агуулга болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн эрсдэлээс сэргийлэх эрх зүйн орчин бүрдэж, хүүхдийн нийгмий сүлжээний хэрэглээний соёл төлөвшихөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Мөн эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч болон харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийн нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалах чиг үүрэг болон нийгмийн сүлжээн дэх хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар төрийн эрх бүхий байгууллагын чиг үүргийг тодорхой болгосон.

Хуулийн тандан судалгаагаар хүүхдүүдийн 88.2 хувь, эцэг эх, асран хамгаалагчдын 92.4 хувь, боловсролын байгууллагын 94.6 хувь нь нийгмийн сүлжээний болон агуулгын хязгаарлалт шаардлагатай гэж үзсэн байна. Өргөн хүрээний оролцогч талуудын дунд хийсэн энэхүү судалгааны үр дүн нь хуулийн төсөл нь нийгмийн бодит хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй болохыг харуулж, гурван чухал хэмжүүрийн дагуу хүлээн зөвшөөрөгдөхөөр байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх нь нийгмийн сүлжээний зохицуулалтын шаардлагатай байгааг өөрсдөө хүлээн зөвшөөрсөн нь онцгой ач холбогдолтой байна. Энэ нийгмийн сүлжээнд өөрийн аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байгааг илтгэж байна. Мөн эцэг эх, асран хамгаалагчдын 92.4 хувь нь нийгмийн сүлжээний хэрэглээ, цахим орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэрэгсэл дутмаг, энэ төрлийн эрсдэл, бодит бэрхшээлтэй тулгарч байгаа тул хууль эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх сонирхлыг илэрхийлж байна.

Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын нэг болох боловсролын байгууллагуудын 94.6 хувь нийгмийн сүлжээний хэрэглээ болон агуулгын зохицуулалт шаардлагатай гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Боловсрол, сургалтын байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа цахим орчны сөрөг нөлөөлөл хүүхдийн хөгжил, суралцах чадварт үзүүлж буй нөлөөллийг шууд ажиглаж байгаа тул тэдний дэмжлэг нь практик хэрэгцээнд суурилсан бодит үнэлгээг илэрхийлж байна. Энэ нь хуулийн төслийн заалтууд хэрэгжилтийн шатанд боловсролын байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагааг татан оролцуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь зөвхөн хууль тогтоомжийн шаардлагыг хангасан хэлбэрийн зохицуулалт биш, харин нийгмийн хүлээлт, олон нийтийн дэмжлэгт тулгуурласан, хэрэгжих бодит суурьтай, иргэд болон байгууллагын хамтын эрэлт хэрэгцээнд нийцсэн зохицуулалт болохыг тандан судалгааны дүн тодорхой харуулж байна.

Гэвч хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад тодорхой зардал үүсэх боловч урт хугацаанд зохистой хэрэглээ бүхий нийгмийн сүлжээний орчин бүрдэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, насанд тохироогүй, хүүхэд хортой болон хориотой хууль бус агуулгаас хамгаалж, нийгмийн сүлжээн дэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Мөн хэрэглэгчийн нас баталгаажуулахтай холбоотойгоор хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагчийн иргэний бүртгэлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах шаардлага гарч байгаа тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн мэдээллийн бүрэн бүтэн, хүртээмжтэй, нууцлалтай байдлыг хангах хэрэгтэй. Энэ хүрээнд нас баталгаажуулахад үүрэн холбооны байгууллагын гар утасны дугаар, иргэний бүртгэлийн мэдээллийг ашиглах бөгөөд хүний хувийн мэдээллийг нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид дамжуулахгүй бөгөөд хэрэглэгчийн насны бүлгийг дамжуулахаар хуулийн төсөлд тусгасан нь Хувийн мэдээлэл хамгаалах хуульд нийцэж байна.

Мөн VPN болон түүнтэй адилтгах технологи ашиглан нас баталгаажуулах болон хортой болон хүүхдэд хориотой агуулгын хязгаарлалтыг тойрон нэвтрэхийг техникийн хувьд бүрмөсөн хориглож чадахааргүй байна. Нийгмийн сүлжээ ашиглахыг хүүхдэд хориглох хуулийг хэрэгжүүлж буй Австрали, Их Британи зэрэг улсын туршлагаас үзэхэд технологийн хувьд 100 хувь хаах боломжгүй гэдэг нь практикт харагдаж байна.

Түүнчлэн хуулийн хэрэгжилт нь технологийн хязгаарлалтад тулгуурлахаас гадна төрийн байгууллага, боловсрол сургалтын байгууллага, эцэг эхийн хяналтын нэмэгдүүлж, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүргийн хэрэгжилтээр хангагдах онцлогтой байна.

Дээр дурдсан судалгааны үр дүнгээс үзэхэд хуулийн төслийг хэрэгжүүлэхэд гол оролцогч талууд болох хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч болон боловсролын байгууллагууд нийгмийн сүлжээний хязгаарлалтын хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байгаа тул хүлээн зөвшөөрөгдөх шаардлагыг хангасан байна.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлуудыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 5.

| Д/д | Аргачлалд заасан асуулт | Хуулийн төслийг үнэлсэн байдал |
|-----|---|--|
| 1. | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилго, зорилттой нийцэж байна. |
| 2. | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн байна. |
| 3. | хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна. |
| 4. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Тийм |

| | | |
|-----|--|---|
| 5. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Үгүй |
| 6. | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Тийм |
| 7. | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Үгүй |
| 8. | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Үгүй |
| 9. | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | |
| 10. | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Үгүй |
| 11. | Хуулийн төсөлд тусгагдсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх | Үгүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй |
| 12. | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Үгүй |
| 13. | Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Тийм |
| 14. | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Үгүй. Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой. |
| 15. | Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгасан эсэх | Үгүй |

| | | |
|-----|--|---|
| 16. | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх. | Тийм. Тухайн хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна гэж тусгасан. |
|-----|--|---|

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1.Баримтжуулалт

Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийж, зорилгод хүрсэн эсэх, хэрэглэхэд ойлгомжтой эсэх, хэрэгжүүлэгч талуудад хүлээн зөвшөөрөгдөх эсэх, бусад хуультай уялдсан эсэх зэргийг судлахдаа холбогдох хэд хэдэн хуулиас гадна дараах нэмэлт баримт бичиг, бусад материалыг ашигласан болно. Үүнд:

- Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, түүний танилцуулга;
- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан;
- Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос ирүүлсэн санал;

4.2.Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлж, дараах байдлаар дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хуулийн төслийн тандан судалгаагаар тодоройлсон 6 төрлийн асуудлыг хуулийн төслийн зорилго болон зүйл заалт хэрхэн нийцэж, зохицуулж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Ойлгомжтой байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын дагуу үнэлэхэд Хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагыг хангаж байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хуулийн төсөлд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад зөвхөн технологийн хязгаарлалтад бус, эцэг эхийн оролцоо, боловсрол, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг тусгасан нь хүүхэд, эцэг эх, сургалтын байгууллагын

дунд хийсэн судалгаанд дурдсан нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хууль эрх зүйн зохицуулалт хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслийн хүрээнд тодорхой асуултуудад хариулах замаар үнэлэхэд хуулийн уялдаа холбоо хангагдаж байна.

~~oOo~~